



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/101

Улаанбаатар хот

Эрдэм шинжилгээ, инновацын хурал зохион байгуулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.16, 4.9.21, 10.2 дугаар заалт, ШУТИС-ийн 2025-2026 оны хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуанлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдмийн чуулган-2026” Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл, инновацын бүтээл шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрдэм шинжилгээний хуралд магистрантур, докторантурт суралцаж буй оюутнуудыг өргөнөөр оролцуулахыг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, Нээлттэй боловсролын хүрээлэнгийн захирал нарт даалгасугай.

3. Арга хэмжээтэй холбогдох зардлыг батлагдсан төсвийн дагуу гаргахыг Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн проректор (Д.Цолмонбаатар), Санхүү, хөрөнгө оруулалтын албаны ахлах нягтлан бодогч (Б.Мөнхцэнгэл) нарт зөвшөөрсүгэй.

РЕКТОР



Т.НАМНАН



**МАГИСТР, ДОКТОР ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦЫН ХУРАЛ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2026.03.23

Улаанбаатар хот

ШУТИС-ийн Ректорын 2011 оны А-63 дугаар тушаалаар баталсан “ШУТИС-д магистр, доктор(Ph.D)-ын сургалт явуулах, зэрэг хамгаалуулахад баримтлах журам”-ын 9.25, 9.26 дугаар заалтуудыг үндэслэн ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээ, инновацын хурлыг зохион байгуулах, магистрант, докторантын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлтэй уялдуулах, бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлж шалгарсан шилдэг судалгааны ажлын үр дүн, инновацийн бүтээгдэхүүнийг хэлэлцүүлэх, сурталчлах, харилцан хамтран ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, эрдэм шинжилгээ, инновацын хурал зохион байгуулах үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллахад энэхүү удирдамжийн зорилго оршино.

Эрдэм шинжилгээ, инновацийн бүтээгдэхүүнд дараах шийдлүүд байна. Үүнд:

1. Доктор, магистр оюутны судалгааны ажлын шинжлэх ухааны үр дүн,
2. Судалгаанд суурилсан технологийн болон нийгмийн инновацын шийдэл,
3. Судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбосон шийдлүүд,

Эрдэм шинжилгээний хурлыг дараах үндсэн чиглэлүүдээр зохион байгуулна. Үүнд:

1. Инженер, техникийн ухаан
2. Хэрэглээний шинжлэх ухаан
3. Нийгэм, хүмүүнлэг, дизайн

Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах хугацаа, үе шат

ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлыг дөрвөн үе шаттайгаар зохион явуулна.

Нэгдүгээр шат: Бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын хүрээлэн дээр магистр, доктор оюутны эрдэм шинжилгээ, инновацын хурлыг 2026 оны 03-р сарын 17-оос 04-р сарын 11-ны өдрүүдэд зохион байгуулна.

Хоёрдугаар шат: Бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын хүрээлэн дээр зохион байгуулагдсан магистр, доктор оюутны эрдэм шинжилгээ, инновацын хурлаас эрдэм шинжилгээний илтгэлд магистр оюутны 3, доктор оюутны 3, инновацын бүтээгдэхүүнд магистр оюутны 3, доктор оюутны 3 бүтээгдэхүүнийг тус тус хянан магадалж, шаардлага хангасан бүтээлийг 2026 оны 4 дүгээр сарын 14-ны дотор Ахисан түвшний сургуульд хэвлэмэл болон цахим, бүтээгдэхүүний загвар, бүтээлийн хамтаар ирүүлнэ.



Гуравдугаар шат: 2026 оны 4 дүгээр сарын 14-23-ны хооронд бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын хүрээлэнгээс ирүүлсэн бүтээлд хяналтын магадлагаа хийж, хуралд оруулах шаардлага хангасан эсэхийг шийдвэрлэнэ.

Дөрөвдүгээр шат:

ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээ, инновацын хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 24, 25-ны өдөр зохион байгуулж, шилдэг илтгэл, инновацийн бүтээгдэхүүнийг шалгаруулж, бүтээлээр үзэсгэлэн зохион байгуулна.

Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэлд тавигдах шаардлага

Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэлд дараах шаардлагыг тавина. Үүнд:

1. Судалгааны ажлын зорилго, зорилт тодорхой, асуудал дэвшүүлсэн байх;
2. Шинжлэх ухаан, инновацийн шинэлэг тал, үр дүнг тодорхой тусгасан байх;
3. Судалгааны ажлын арга, аргачлалыг тодорхой гаргаж өгөх;
4. Судлаачдын бүтээлээс магистрант 6-аас доошгүй, докторант 12-оос доошгүй эшлэл авсан байх;
5. Бүтээлийн хуулбарлалтыг шалгуулсан байх;
6. Илтгэх үр чадварыг эзэмшсэн байх;
7. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлд хэвлүүлэх эрдэм шинжилгээний өгүүллийн шинэчилсэн загварын дагуу бичигдсэн байна.

Инновацийн бүтээлд тавигдах шаардлага

Энэ нь судалгааны ажлын үр дүнд бий болсон технологийн шийдэл, программ хангамж, системийн загвар, нийгмийн инновац, шийдэл, менежментийн аргачлал зэрэг бодит хэрэглээтэй үр дүн байна. Үүнд:

1. Инновацийн санаа, шийдвэрлэх асуудал тодорхой байх;
2. Шинэлэг байдал, инновацийн онцлогийг тодорхой тусгасан байх;
3. Судалгааны үндэслэл, шийдлийн аргачлал тодорхой байх;
4. Бүтээлийн туршилт, баталгаажуулалт хийгдсэн байх;
5. Хэрэглээний боломж, үр нөлөөг тодорхойлсон байх;
6. Бүтээлийн загвар, прототип эсвэл системийн танилцуулга бэлтгэсэн байх;
7. Оюуны өмчийн хамгаалалтын боломжийг тодорхойлсон байх;
(Бүтээл нь патент, ашигтай загвар, программ хангамжийн эрх, зохиогчийн эрх зэрэг оюуны өмчийн хамгаалалт авах боломжийг тодорхойлсон байх)
8. Танилцуулга, илтгэл бэлтгэсэн байх; (Бүтээл нь инновацийн санаа, шийдэл, туршилт, хэрэглээний боломжийг ойлгомжтой танилцуулах илтгэл, постер, прототипийн үзүүлэн бүхий байдлаар бэлтгэгдсэн байх)
9. Эрдэм шинжилгээ, инновацийн хурлын бүтээлийн эмхэтгэлд тавигдах шаардлагын дагуу бичигдсэн байх;
10. Инновацийн бүтээгдэхүүн нь хурлын эмхэтгэлд хэвлэгдэх инновацийн товч тайлан, техникийн тодорхойлолт, бүтээлийн танилцуулга бүхий баримт бичигтэй байна.



ШУТИС-ийн ректорын тушаалаар 2019 оны 03 сарын 05 -ны өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээ, инновацын хуралд дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

1. Бүрэлдэхүүн болон харьяа сургууль, Нээлттэй боловсролын хүрээлэнгийн захирлын зөвлөлийн хурлын шийдвэр;
2. Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих зааврын дагуу өгүүлэл, инновацын бүтээлийн танилцуулгыг бичиж ирүүлнэ.
3. Эрдэм шинжилгээний өгүүллийн агуулгын давхцалын хувь хэмжээ 40 хувиас доош байна. Агуулгын давхцалыг шалгасан хуудсыг хавсаргана.
4. Инновацийн бүтээл нь тухайн оюутны судалгааны ажлын үр дүн болохыг баталгаажуулсан удирдагч багшийн тодорхойлолтыг хавсаргана.
5. Эрдэм шинжилгээний өгүүллийг ШУТИС-ийн ерөнхий редакцийн зөвлөлийн гишүүд уншиж, баталгаажуулсан байна.
6. Дээрх зааврын дагуу бэлтгээгүй, шаардлага хангаагүй бүтээлийг хүлээж авахгүй.

Шалгаруулалт ба шагнал урамшуулал

ШУТИС-ийн Ректорын тушаалаар томилогдсон комиссын бүрэлдэхүүн шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл, инновацын бүтээлийг тус тусад нь шалгаруулна. Салбар, чиглэл бүрээр ирүүлсэн илтгэл, бүтээлийг хөтөлбөрийн дагуу хэлэлцэж, салбар бүрээс магистрант, докторантын тус бүр 3 илтгэл, 3 инновацийн бүтээл шалгаруулна.

Инженер, техникийн ухааны салбар

- | | |
|----------|-----------------------------------|
| I байр | Батламж, 2.0 кредитийн урамшуулал |
| II байр | Батламж, 1.5 кредитийн урамшуулал |
| III байр | Батламж, 1.0 кредитийн урамшуулал |

Хэрэглээгний шинжлэх ухааны салбар

- | | |
|----------|-----------------------------------|
| I байр | Батламж, 2.0 кредитийн урамшуулал |
| II байр | Батламж, 1.5 кредитийн урамшуулал |
| III байр | Батламж, 1.0 кредитийн урамшуулал |

Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбар

- | | |
|----------|-----------------------------------|
| I байр | Батламж, 2.0 кредитийн урамшуулал |
| II байр | Батламж, 1.5 кредитийн урамшуулал |
| III байр | Батламж, 1.0 кредитийн урамшуулал |

Инновацын бүтээл

- | | |
|----------|-----------------------------------|
| I байр | Батламж, 2.0 кредитийн урамшуулал |
| II байр | Батламж, 1.5 кредитийн урамшуулал |
| III байр | Батламж, 1.0 кредитийн урамшуулал |


ШУТИС-ийн ректорынхон 2026 оны 03 сарын 25 -ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эрдэм шинжилгээ, инновацын хуралд хэлэлцүүлсэн илтгэл, бүтээлийг “ШУТИС-ийн магистр, доктор оюутны эрдэм шинжилгээ, инновацын бүтээлийн эмхэтгэл”-д өгүүлэл, хураангуй болгон хэвлүүлж, зохиогчдод эмхэтгэлийг хүргүүлнэ. Инновацын шилдэг бүтээлүүдийг инновацын төсөл боловсруулах, стартап хөгжүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, патентын мэдүүлэг гаргах зэрэгт ШУТИС-ийн зүгээс дэмжин, нийтэд сурталчилан таниулна.

Ахисан түвшний сургууль
Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн алба
Инновац, бизнес түншлэлийн алба

--- оОо ---



ШУТМС-ийн захирлын газрын 2023 оны 03 сарын 25-ны өдрийн дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл, инновацийн бүтээлийг шалгаруулах комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:	Доктор (Ph.D), профессор Д.Цолмонбаатар	Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн проректор
Гишүүд:	Доктор (Ph.D), профессор И.Цэрэн-Онолтг Доктор (Ph.D), Ц.Цоггэрэл Магистр М.Зулбаяр Доктор (Ph.D), дэд профессор Н.Мөнхөө Магистр, Д.Батдорж Магистр, Ж.Батбаяр Магистр, Н.Бадрах Доктор (Ph.D), Г.Адъяажав Доктор (Ph.D), Э.Чимэдлхам Доктор (Ph.D), дэд профессор О.Мөнхцэцэг Доктор (Ph.D), П.Цэрэнчимэд Доктор (Ph.D), дэд профессор Б.Оюунтунгалаг Доктор(Ph.D), дэд профессор Х.Загарзүсэм Доктор (Ph.D), дэд профессор Л.Амартүвшин Доктор (Ph.D), Г.Солонго Доктор (Ph.D), Х.Отгондорж Доктор(Ph.D), Д.Үлэмж Доктор (Ph.D), дэд профессор Д.Баясгалан Доктор (Ph.D), профессор Д.Ганбат Доктор (Ph.D), дэд профессор Х.Отгон-Эрдэнэ	Ахисан түвшний сургуулийн захирал Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн албаны дарга Инновац, бизнес түншлэлийн албаны дарга Ахисан түвшний сургуулийн дэд профессор Ахисан түвшний сургуулийн ахлах мэргэжилтэн Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн албаны мэргэжилтэн Инновац, бизнес түншлэлийн албаны ахлах мэргэжилтэн БАС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ГХС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ГУУС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга МИТС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга МС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга МХТС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга НХС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ХХҮДС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ХШУС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ЭХИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга ДарТС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Нээлттэй боловсролын хүрээлэнгийн захирал Ахисан түвшний сургуулийн ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:		